

Номын номзүйн бичилт

Номзүйн бичилт хийгдэх судлагдахуун нь ном, товхимол, төрөл бүрийн нэг ба олон ботит хэвлэлүүд болно.

Нэг ботит номуудад нэг сэдэвт номзүйн бичилт, харин олон ботит хэвлэлд нэгдсэн номзүйн бичилт хийнэ.

	Толгой гарчиг
	Үндсэн гарчиг: Гарчигт хамааралтай бусад мэдээнүүд / Оролцогчдын тухай эхний мэдээнүүд; Оролцогчдын тухай дараах мэдээнүүд .- Хэвлэлийн тухай мэдээнүүд .- Хэвлэгдсэн газар : Хэвлэлийн газар, Хэвлэгдсэн он .-Хуудас: зураг; хэмжээ + дагалдах материал .- (Дээд гарчигийн мэдээ).- тайлбар.- ISBN: Үнэ, Хэвлэгдсэн тоо

Номзүйн мэдээний эх сурвалжууд нь дараах байдлаар тодорхойлогдоно.

- Нүүр хуудас
 - Хавсарсан нүүр хуудас
 - Нүүр хуудасны ар тал
 - Хавтас
 - Гарчиг
 - Оршил гэх мэт орно.
- Нэг сэдэвт (нэг ботит) номзүйн бичилт нь нэг хэсгээс бүрдэнэ.
- Нэгдсэн номзүйн бичилт нь (Олон ботит) ерөнхий хэсэг ба тусгай хэсгээс бүрдэнэ.

Зарим тохиодолд зөвхөн ерөнхий хэсгээс бүрдэнэ.

Нэг ботит хэвлэлийн (номын) номзүйн бичилтийн хэсэг болон элементүүдийг доорх дэс дарааллаар байрлуулна.

1. Толгой гарчиг
2. Гарчиг ба оролцогчдын тухай мэдээний хэсэг
 Үндсэн гарчиг

- = зэрэгцээ гарчиг
- : гарчигт хамааралтай бусад мэдээнүүд

Оролцогчдын тухай мэдээнүүд

- / эхний мэдээ
- ; дараах мэдээнүүд

3. Хэвлэлийн хэсэгт:

Хэвлэлийн тухай мэдээ

Тус хэвлэлд хамаарагдах, оролцогчдын тухай мэдээнүүд

- / Эхний мэдээнүүд
- ; дараагийн мэдээнүүд
- , Хэвлэлийн тухай нэмэлт мэдээнүүд

4. Гаралтын мэдээний хэсэгт:

Хэвлэгдсэн газар

- .- Эхний хэвлэгдсэн газар
- ; Дараагийн хэвлэлийн газар
- : Хэвлэлийн газар
- , Хэвлэгдсэн он

5. Тооны тодорхойлолтын хэсэгт:

Хэмжээ / Хуудас/

- : зураг
- ; Хэмжээ /овор/
- + Дагалдах материал

6. Тайлбар хэсэг

Номын олон улсын стандартын дугаар (ISBN), үнэ, хэвлэгдсэн тоо ширхэг

- .- ISBN
- : Үнэ
- , Хэвлэгдсэн тоо (Номын санд байгаа тоо)

Ном тодорхойлсон жишээ:


2018 онд хэвлэгдсэн номын сангийн үндсэн ойлголтууд ном тодорхойлсон жишээ.

Номын гадна хавтас:




Зураг № 1

Номын дотор нүүр:




Зураг № 2

Номын дотор нүүр:




Зураг № 3

Тухайн ном нь зурагтай байна.



Зураг № 4

Нийт хуудасны тоо:



Зураг № 5

Ном тодорхойлж байгаа хүн эхлээд тодорхойлох номын мэдээллээ дараах хүснэгт бөглөх замаар бүрдүүлбэл илүү хурдан сурдаг.

Толгой гарчиг (Зохиогч)	Хайдав Т. (Толгой гарчигт зохиогчийн нэрийг бичээд ард нь овгийн эхний үсэг бичнэ.)
Үндсэн гарчиг (Номын нэр)	Номын сангийн үндсэн ойлголтууд (Номын нэрийг дотор нүүрнээс хараарай)
= зэрэгцээ гарчиг	(Хэрэв номын нэрийг англи, орос гэх мэт өөр хэлээр давхар бичсэн тохиолдолд энд бичиж болно.)
: гарчигт хамааралтай бусад мэдээнүүд	гарын авлага (Номын нэрийг тодотгох тэрхүү мэдээлэл энд бичигдэнэ. Жнь: роман, тууж.)
/ Оролцогчдын тухай эхний мэдээ ; дараах мэдээнүүд	/ Ред. Б.Баяраа (Зураг №3 үз.) ; эх бэлтгэсэн Д.Энхнасан (Зураг №3 үз.)
.- Эхний хэвлэгдсэн газар ; Дараагийн хэвлэлийн газар	.- УБ. (Зураг №2 үз.)
: Хэвлэлийн газар	: Амжилтын гарц ХХК. (Зураг №3 үз.)
, Хэвлэгдсэн он	, 2018 (Зураг №2 үз.)
.- Хэмжээ / Хуудас/	.- 168 х. (Зураг №5 үз.)
: зураг	: зур. (Зураг №4 үз.)
; Хэмжээ /овор/	; 29см. (Зураг №1 үз.)
+ Дагалдах материал	
.- Тайлбар	
.- Дээд гарчигийн мэдээ	.- (Шинэ үеийн номын сан)
.- ISBN	.- 978-99978-2-546-9 (Зураг №3 үз.)
: Үнэ	: 25000 төг. (Худалдаж авсан баримт үз.)
, Хэвлэгдсэн тоо (Номын санд байгаа тоо)	, 10ш. (Номын санд хэдэн ширхэг байгаа тоог бичих.)

Энэ хүснэгтэд номын талаарх мэдээллүүдээ оруулсан бол каталогийн картад байгаа талбарын нэрийг өөрчлөөд л болчихно. Дараах зураг харна уу.

	Толгой гарчиг
	<p>Үндсэн гарчиг: Гарчигт хамааралтай бусад мэдээнүүд / Оролцогчдын тухай эхний мэдээнүүд; Оролцогчдын тухай дараах мэдээнүүд .- Хэвлэлийн тухай мэдээнүүд .- Хэвлэгдсэн газар : Хэвлэлийн газар, Хэвлэгдсэн он .-Хуудас: зураг; хэмжээ + дагалдах материал .- (Дээд гарчигийн мэдээ).- тайлбар.- ISBN: Үнэ, Хэвлэгдсэн тоо</p>

020	Хайдав Т.
х 163	<p>Номын сангийн үндсэн ойлголтууд: гарын авлага / ред. Б.Баяраа; эх бэлтгэсэн Д.Энхнасан .-УБ.:Амжилтын гарц ХХК., 2018.- 168х.: зур; 29 см.- (Шинэ үеийн номын сан).- 978-99978-2-546-9: 25000 төг.,10ш.</p>

Анхаар:

Энэ лекцийг хэвлэсний дараа анхааралтай ажиглаад тус бүр 5 ном тодорхойлж дасгал ажиллаарай.